



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/339

Ховд

Эрх шилжүүлэх тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хог хаягдлыг ангилан ялгах, хогны менежментийг хэрэгжүүлэхэд зориулан 21 000 000 төгрөгийг зарцуулсугай.


2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 21 000 000 төгрөг /хорин нэгэн сая/-ийг аймгийн техник, хяналтын зардлаас санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д тус тус зөвшөөрсүгэй.

3. “Хог хаягдлыг ангилан ялгах, хогны менежментийг хэрэгжүүлэх ажил”-ын зардлыг хавсралтаар баталсугай.

4. Дээрх арга хэмжээг “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хууль”-ийн хүрээнд зохион байгуулж, гүйцэтгэгчтэй хамтран ажиллах гэрээг байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, хүлээн авах, тайлагнах эрхийг Жаргалант сумын Засаг дарга /С.Гантөмөр/-д шилжүүлсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




Б.ДҮГЭРЖАВ

Zax A/339 Ch

02 01430

Аймгийн Засаг даргын 2020 оны  
06 дугаар сарын 29-ний өдрийн  
А/339 дүгээр захирамжийн хавсралт



“ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАН ЯЛГАХ, ХОГНЫ МЕНЕЖМЕНТИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ”-ЫГ ГҮЙЦЭТГЭХ ЗАРДЛЫН ЖАГСААЛТ

№	Үйл ажиллагаа	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /төг/	Нийт дүн /мян.төг/	Тайлбар
1	Хог хаягдлыг ангилан ялгах, хогны менежментийг хэрэгжүүлэх	төсөл	1	21000000	21000000	Ховд хотын дахин ашиглах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг дэмжих
Дүн					21 000 000	

-оОо-